Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 43 хэрэгжүүлэх арга хэмжээтэй боловсруулан баталснаас хэрэгжилт 95,6%-тай дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд Засаг даргын Тамгын газрын дарга 1, удирдах 3 гүйцэтгэх 16, гэрээт ажилтан 6 бүгд 26 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Засаг захиргаа нутаг дэвгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн "Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай" А/03 тушаал, 5 хүний бүрэлдэхүүнтэй, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг мөрдөж ажиллаж байна.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналт шалгалтын хэсэг нь тайлант онд дотоод хяналт шалгалт явуулахаар 5 хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг гарган ажилласан байна.

Байгууллагын дотоод хяналтын баг нь жилийн төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт санхүүгийн үйл ажиллагаанд хийж, алдаа зөрчил гарвал тухай бүрд нь засаж залруулах зөвлөмж өгч эргэн хяналт тавьж ажилладаг. Энэ онд шилэн дансанд хяналт шалгалт хийсэн байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын

найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газрын 2013 онд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба энэхүү баримт бичиг нь 4 бүлэгт бүртгэлийн үйл ажиллагааг тусгасан байна. НББ-ийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 223,721.4 мянган төгрөгөөр буюу 10,2 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

**(мянган төгрөгөөр)**

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| A | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | 3,879.6 | 3,879.6 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 81,536.3 | 120,803.5 | 39,267.2 |
| Үндсэн хөрөнгө | 2,113,913.9 | 2,294,488.5 | 180,574.6 |
| Нийт хөрөнгө | 2,195,450.1 | 2,419,171.5 | 223,721.4 |
| Өр төлбөр | - | 103.0 | 103.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,195,450.1 | 2,419,068.5 | 223,618.4 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 2,195,450.1 | 2,419,171.5 | 223,721.4 |

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 583,443.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 20,0074.0 мянган төгрөгөөр бууруулж Төв аймгийн

Цээл сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 05 дугаар тогтоолын хавсралтаар 2023 оны урсгал зардлын төсвийг 563,369.6 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн.

Тайлант хугацаанд төсөвт 1 удаагийн тодотгол хийгдэж 2023 оны 8 дугаар сарын 08-ний өдрийн 05 дугаар тогтоолоор 65,147.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 628,516.8 мянган төгрөгөөр ирүүлсэн байна. Энэ нь урсгал зардлын хэмжээг 65,147.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээс шалтгаалжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн хэрэгжүүлэх 2 /орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, хүрээлэн буй орчны бодлого, удирдлага/ хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 426,797.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсан дагуу гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 29,320.2 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 603,197.7 мянган төгрөг буюу 97,7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 29,319.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

**(мянган төгрөгөөр)**

| д/д | Хөтөлбөр арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Үндсэн үйл ажиллагааны зардал | 446,381.7 | 425,312.8 | 21,069.8 | 106.4 |
| 2 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ | 60,225.5 | 54,617.9 | 5,607.6 | 90.7 |
| 3 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Баг, хорооны үйл ажиллагааны зардал | 96,467.9 | 93,904.6 | 2,563.3 | 97.3 |
| 4 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 1,000.0 | 995.5 | 4.5 | 99.6 |
| 5 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Бусад | 15,000.0 | 15,000.0 | 0.0 | 100.0 |
| 6 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Орон нутгийн нөөц хөрөнгө | 5,000.0 | 4,924.4 | 75.6 | 98.5 |
| 7 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Улсын их баяр наадам | 5,000.0 | 5,000.0 | 0.0 | 100.0 |
| 8 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | 3,442.5 | 3,442.5 | 0.0 | 100.0 |
|  | Дүн | 632,517.6 | 603,197.7 | 29,319.9 | 97.7 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Цэээл сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн

дансанд дээд шатны төсөв захирагчаас 88,704.9 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаас 9,416.0 мянган төгрөг, үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 50,217.3 мянган төгрөг, нийт 148,338.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ. Үүнээс 24,937.1 мянган төгрөг нь газрын дуудлага худалдааны дэнчингийн орлого байсныг оролцогчид буцааж өгч орлого бууруулах бичилт хийсэн байна.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар албан хаагчдад орон нутгийн нэмэгдэлд 24,419.5 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 3,052.4 мянган төгрөг хангамж бараа материалын зардалд 6,015.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд 605.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 21,409.9 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 59,828.5 мянган төгрөг нийт 115,322.4 мянган төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### *3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

**(мянган төгрөгөөр)**

| д/д | Хөтөлбөр арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/- 80101 /Үндсэн үйл ажиллагааны зардал | 2023.01.01 2023.12.31 | | | 446,381.7 | 425,312.8 |
| 2 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/- 80103 /Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ | 2023.01.01 2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ | | 60,225.5 | 54,617.9 |
| 3 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/- 80106 /Баг, хорооны үйл ажиллагааны зардал | 2023.01.01 2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Баг, хорооны үйл ажиллагааны зардал | | 96,467.9 | 93,904.6 |
| 4 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/- 80802 /Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 2023.01.01 2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | | 1,000.0 | 995.5 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/- 80918 /Бусад | 2023.01.01 2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Бусад | | 15,000.0 | 15,000.0 |
| 6 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/- 81102 /Орон нутгийн нөөц хөрөнгө | 2023.01.01 2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Орон нутгийн нөөц хөрөнгө | | 5,000.0 | 4,924.4 |
| 7 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/- 82801 /Улсын их баяр наадам | 2023.01.01 2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Улсын их баяр наадам | | 5,000.0 | 5,000.0 |
| 8 | 71411 /Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага/- 81701 /Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | 2023.01.01 2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | | 3,442.5 | 3,442.5 |
| 9 | 71411 /Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага/-/- 82212 /Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ | 2023.01.01 2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | | 11,000.0 | |
| | Дүн | | | | 643,517.6 | |

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газар нь төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажилласнаар нийт 37,397.9 мянган төгрөгийн зардлыг хэмнэж, дутуу зарцуулсан нь хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлсөн байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Орон нутгийн хөгжлийн сан болон төсвийн хөрөнгө оруулалтаар Нарангийн шовх ХХК-тай харьцуулалтын аргаар худалдан авах гэрээ хийж 58,564.9 мянган төгрөгийн спорт чийрэгжүүлэлт, тоглоомын талбайн тоног төхөөрөмж, Саммит компьютер ХХК-тай шууд худалдан авах гэрээ хийж 14,013.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Их жэт ХХК-тай шууд худалдан авах гэрээ байгуулж 4,906.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, Скай дизайн хаус ХХК-тай шууд худалдан авах гэрээ байгуулж 5,916.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан байна. Худалдан авах ажиллагааны журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж хөрөнгө, материалыг данс бүртгэлд тусгаж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одбилэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 04/08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны нийт орлого 1,292,361.4 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 19,385.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 14,539.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор нийт 37,397.9 мянган төгрөгийн зардлыг хэмнэж ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 166 мэдээлэл байршуулахаас 162 мэдээллийг хугацаандаа, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлэл байршуулалт 89,6 хувьтай байна. Мөн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12 орлогын, 28 зарлагын мөнгөн гүйлгээг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-

т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

***Шийдвэрлэсэн нь:*** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар 18,555.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж, 15,942.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 600.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож нийт 35,098.4 мянган төгрөгийн зөрчил илрүүлсэн байна. Завсрын аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилгаж биелэлтийг ирүүлсэн байна.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 04/107 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | 2 | 3,035.6 | 2 | 3,035.6 | 100 |
| **Нийт дүн** | **2** | **3,035.6** | **2** | **3,035.6** | **100** |

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газрын дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 114,358.7 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 110,479.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,879.6 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

***1.Илрүүлэлт:*** Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн уялдааг тулгаж үзэхэд мөнгөн гүйлгээний тайланд төсвийн хөрөнгөөр худалдан авсан биет бус хөрөнгийн дүнг салгаж тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Шийдвэрлэсэн нь:*** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

***2.Илрүүлэлт:*** Үндсэн хөрөнгийн тодруулгын тайлангийн худалдан авсан дүнг мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгийн зардалтай тулгахад 9,515.9 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Шийдвэрлэсэн нь:*** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 662,895.2 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 13,455.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 649,440.1 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

### 5.1 Төлбөрийн акт

*1. Илрүүлэлт:* Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн Б/02 тоот захирамж болон, сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн Б/01 захирамжийг үндэслэн Монгол улсын Засгийн газрын 489 дүгээр тогтоолыг зөрчиж улс төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл 12,649.6 мянган төгрөг олгож төсвийг үр ашиггүй зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр "Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай " тогтоол 018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар "Журам батлах тухай" тогтоол болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

***Шийдвэрлэсэн нь:*** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" бол төлбөрийн акт тогтооно гэсний дагуу шийдвэрлэв.

*2. Илрүүлэлт:* Нийгмийн даатгалын улсын байцаагчийн 2021 оны 34 дүгээр актаар тогтоосон алдангийг төсвөөс төлсөн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар зарцуулах" гэсэн заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" бол төлбөрийн акт тогтооно гэсний дагуу шийдвэрлэв.

**5.2 Албан шаардлага**

*1. Илрүүлэлт:* Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш орлогын 28 мөнгөн гүйлгээ болон 5 сая төгрөгөөс дээш зарлагын 12 гүйлгээг байршуулаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-д "... хөрөнгө, мөнгө зарцуулах, ... шийдвэр", гэсэнтэй нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг", батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагатай холбоотой асуудал

*1.Илрүүлэлт:* "Монголын баялаг 330" төсөл хөтөлбөрийн хүрээнд соёлын өвийг дүрсжүүлэн архив, үүсгэх ажлын гэрээ байгуулж Монголын баялаг өв соёл ХХК-д авлага үүсгэлгүйгээр 3,879.6 мянган төгрөг шилжүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж, холбогдох анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэж санхүүгийн тайланд өглөг, авлагыг бүрэн тусгах.

Дээрх зөрчлийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 6 дугаарсарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | | Үүнээс Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн уялдааг тулгаж үзэхэд мөнгөн гүйлгээний тайланд төсвийн хөрөнгөөр худалдан авсан биет бус хөрөнгийн дүнг салгаж тайлагнаагүй. | 1 | 100,963.2 | | | 1 | 100,963.2 | 1 | 100,963.2 | | | | |
| Үндсэн хөрөнгийн тодруулгын тайлангийн худалдан авсан дүнг мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгийн зардалтай тулгахад 9,515.9 мянган төгрөгөөр зөрүүтэй байна | 1 | 9,515.9 | | | 1 | 9,515.9 | 1 | 9,515.9 | | | | |
| "Монголын баялаг 330" төсөл хөтөлбөрийн хүрээнд соёлын өвийг дүрсжүүлэн архив, үүсгэх ажлын гэрээ байгуулж Монголын баялаг өв соёл ХХК-д авлага үүсгэлгүйгээр 3,879.6 мянган төгрөг шилжүүлсэн байна. | 1 | 3,879.6 | 1 | 3,879.6 | | | 1 | 3,879.6 | | | 1 | 3,879.6 |
| Дүн | 3 | 114,358.7 | 2 | 110,479.1 | 2 | 110,479.1 | 3 | 114,358.7 | | | 1 | 3,879.6 |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс Төлбөрийн акт | | Үүнээс Албан шаардлага | | Үүнээс Зөвлөмж | | Үүнээс Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Үүнээс Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг | 1 | 649,440.4 | | | 1 | 649,440.4 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| хангаж ажиллаагүй. | | | | | | | | | | | | |
| Улс төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгосон. | 1 | 12,649.6 | 1 | 12,649.6 | | | | | | | | |
| Нийгмийн даатгалын шимтгэлийн алдангийг төсвөөс төлсөн. | 1 | 805.5 | 1 | 805.5 | | | | | | | | |
| Дүн | 3 | 662,895.5 | 2 | 13,455.1 | 1 | 649,440.1 | | | | | | |